

ТАНИЛЦУУЛГА

Хүнсний барааны үнийн 2018 оны XII сарын 12-ны өдрийн ажиглалт


Нийслэлийн төвийн 6 дүүрэгт байрладаг 12 хүнсний зах, худалдааны төвд хийсэн 33 нэр төрлийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн 2018 оны XII сарын 2-р долоо хоногийн ажиглалтаар өмнөх долоо хоногтой харьцуулахад 20 нэрийн барааны үнэ **тогтвортой**, 2 нэрийн барааны үнэ **буурсан**, 11 нэрийн барааны үнэ **өссөн** байна. Үүнд :

≈ Үнэ тогтвортой	↓ Үнэ буурсан	↑ Үнэ өссөн
<ul style="list-style-type: none"> "Алтан Тариа" задгай гурил дээд "Алтан Тариа" задгай гурил I "Алтан Тариа" савласан гурил дээд "Алтан Тариа" савласан гурил I "Алтан Тариа" савласан гурил II "Алейка" гурил дээд "Сүү" ХК хайрцагтай 1 л сүү Сүү, задгай Тараг, Цөцгийтэй Цагаан будаа, "Заантай" Шар будаа Цөцгийн тос, Сүү ХК Ургамлын тос, "Янта" Ногоон цай, "Сtimo" Элсэн чихэр, "Заантай" Төмс, монгол Байцай, монгол Хүрэн манжин, монгол Сонгино, хятад, бөөрөнхий Алим, фүжи 	<ul style="list-style-type: none"> "Сүү" ХК савласан 0.5 л сүү Лууван, монгол 	<ul style="list-style-type: none"> "Алтан Тариа" савласан гурил дээдийн дээд Талх, "Атар" Талх, "Зууван чех" Талх, "хөх тарианы хар" Хонины мах, ястай Хонины мах, цул Үхрийн мах, ястай Үхрийн мах, цул Адууны мах, ястай Ямааны мах, ястай Өндөг, ОХУ

Махны дундаж үнэ

2018 оны XII сарын 2-р долоо хоногт хонины ястай мах нэг килограмм нь дунджаар 6680 төгрөг, үхрийн ястай мах нэг килограмм нь дунджаар 8420 төгрөгийн үнэтэй байна. Үхрийн ястай махны үнэ өмнөх долоо хоногтой харьцуулахад 585 төгрөгөөр (7.5%), үхрийн цул махны үнэ 960 төгрөгөөр (10.4%) тус тус өссөн байна. Энэ долоо хоногийн ажиглалтаар үхрийн мах "Хархорин" хүнсний захад хамгийн хямд буюу 7300 төгрөг, Харин "Меркури" хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 9500 төгрөг байна.

Зураг 1. Үхрийн махны дундаж үнэ, 1 кг




Хүснэгт 1. Нэг килограмм махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөг

Үхрийн ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2013	7 335	8 025	7 895	8 330	8 380	8 275	8 225	7 710	7 825	7 245	7 115	7 280
2014	7 980	7 775	8 425	8 370	8 685	8 730	7 955	7 590	7 635	7 550	7 495	7 465
2015	7 415	7 565	7 810	8 080	8 145	8 445	7 985	7 230	7 005	5 975	5 620	5 520
2016	6 165	6 875	7 105	8 170	8 495	7 930	6 950	6 865	6 120	5 235	5 495	5 580
2017	6 775	7 405	7 785	7 985	8 230	7 905	7 725	7 375	7 250	6 945	6 710	6 505
2018	6 615	7 110	7 740	8 365	8 465	8 735	9 085	8 225	7 780	7 845	8 005	8420*

Хонины ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2013	6 480	7 095	7 060	7 420	7 490	7 470	7 415	6 710	6 540	6 215	6 085	6 245
2014	6 855	6 675	7 040	7 630	7 800	7 685	7 030	6 585	6 395	5 965	5 835	5 940
2015	5 860	6 140	6 735	7 460	7 555	7 455	6 830	6 050	5 540	4 510	4 200	3 930
2016	4 625	5 495	5 970	6 935	6 945	6 525	5 780	5 605	4 940	4 250	3 945	4 390
2017	5 650	6 030	6 675	7 080	7 235	6 700	6 575	6 395	6 210	5 760	5 380	5 140
2018	5 240	5 945	6 560	7 290	7 490	7 515	7 535	6 980	6 415	6 440	6 690	6680*

* 2-р долоо хоногийн ажиглалтаар

Зураг 2. Хонины махны дундаж үнэ, 1 кг



Өмнөх долоо хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 220 төгрөгөөр (3.4%), хонины цул махны үнэ 165 төгрөгөөр (2.4%) өссөн байв. Энэ долоо хоногийн ажиглалтаар хонины мах “Хархорин” хүнсний захад хамгийн хямд буюу 5600 төгрөгөөр, харин “Меркури” хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 7500 төгрөгөөр худалдаалж байна.


Гурилын үнэ

2018 оны XII сарын 2-р долоо хоногт нийслэлийн хүнсний томоохон зах, дэлгүүрт “Алтан тариа” савласан нэг кг гурилын үнэ дээд зэрэг нь 1250-1500 төгрөг, 1-р зэргийнх 1000-1200 төгрөг, 2-р зэргийнх 800-1000 төгрөг байна.


Худалдан авагч олон байдаг “Хүчит шонхор”, “Таван эрдэнэ”, “Бөмбөгөр”, “Баянзүрх”, “Хархорин” хүнсний захуудад задгайгаар буюу шуудайгаар худалдаж буй нэг кг дээд зэргийн “Алтан тариа” гурилын үнэ 1250-1400 төгрөгийн үнэ ханштай байна. Харин “Барс” хүнсний захад дээд зэргийн “Алтан тариа” гурил 1250 төгрөг, 1-р зэргийн гурил 950 төгрөгөөр тус тус зарагдаж байна.



Зураг 3. Дээд зэргийн гурилын үнэ, 1 кг



Зураг 4. Савласан гурилын үнэ, 1кг




“Атар” талх хүнсний зах, дэлгүүрт 1200-1320 төгрөгийн үнэтэй байна. “Баянзүрх”, “Бөмбөгөр”, “Барс”, “Хархорин” хүнсний захуудад “Атар” талхыг хамгийн хямд буюу 1200 төгрөгөөр, харин “Сансар” супермаркетэд хамгийн өндөр үнээр буюу 1320 төгрөгөөр худалдаалж байна.

Хүнсний ногооны үнэ

2018 оны XII сарын 2-р долоо хоногт өмнөх долоо хоногтой харьцуулахад монгол лууван 3.2 хувиар буурч 1075 төгрөгөөр худалдаалагдаж байна.

Зураг 5. Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, төгрөг



Хэрэглээний үнийн ажиглалтын хавсралт хүснэгт:

- Хавсралт 1. Хүнсний барааны үнийн ажиглалт, хүнсний зах, худалдааны төвөөр, 2018.XII.12
- Хавсралт 2. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2018 оны IX, X, XI, XII сар
- Хавсралт 3. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2012-2018 оны XII сарын 12
- Хавсралт 4. Шатахуун, түлшний үнэ, ШТС-аар, 2018.XII.12
- Хавсралт 5. Шатахууны үнийн зэрэгцүүлэлт, 2018 оны IX, X, XI, XII сарын ажиглалтаар
- Хавсралт 6. Шатахууны үнэ өөрчлөгдсөн өдөр, 2018 он
- Хавсралт 7. Түлшний дундаж үнэ, худалдаж буй байршлаар, 2018.XII.12